ҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын  2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2025/016/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2025 он | Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа<br>Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Нарантуяа<br>Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Ариунбаяр<br>Утас: 99076224 Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn |


аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 107

танай ______________-ны №______________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА ХУРАНДАА
Б.БААТАРХҮҮ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Цагдаагийн ерөнхий газраас 411,220.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийлүүлэгдсэн, төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэн нь төсвийн нийт зардал өмнөх оны үзүүлэлтээс 37.3 хувь буюу 1,395,478.3 мянган төгрөгөөр өсөхөд голлон нөлөөлжээ.

**Аудитын гол асуудал**

Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны 01/1021 дугаар албан бичгийн дагуу төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 47,131.7 мянган төгрөгийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн нь төсвийн хэмнэлтийг зохих журмын дагуу төвлөрүүлээгүй, улмаар төсвийн гүйцэтгэлийн тайлангаар эдийн засгийн ангилалд зардал болгон бүртгэснээр төсвийн сахилга бат алдагдах эрсдэл үүсгэсэн байна.

**Бусад асуудал**

D:\Бичиг хэрэг\2025\Явсан бичиг\A4 toot 2025.docx
2225020022

Тайлант онд ЦЕГ-ын хэмжээнд acolous, e-accounting, fiscus зэрэг санхүүгийн программыг ашигласнаас үүдэн тайлан гаргахад хүндрэл, бэрхшээл учирсан нь эдгээр системүүдийн хоорондын нийцүүлэлт, интеграци дутагдалтай байгааг харуулж байна. Үүний улмаас тайлангийн нарийвчлал, бодит байдал алдагдаж, алдаатай мэдээлэл, маргаантай тооцоолол үүсэх эрсдэлтэй. Тиймээс нэгтгэсэн, нийцсэн санхүүгийн программ хангамжийг ашиглах, мэдээллийн урсгалыг сайжруулах, бүртгэлийн системийн интеграци болон хяналтыг тогтмол сайжруулах шаардлагатай байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 402,812,556.08 | 355,427,293.65 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 32,568,777.18 | 52,627,726.18 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 32,568,777.18 | 52,627,726.18 |
| 3121 | Төгрөг | 32,568,777.18 | 52,627,726.18 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 32,568,777.18 | 52,627,726.18 |
| 33 | АВЛАГА | 3,535,452.34 | 3,535,452.34 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,535,452.34 | 3,535,452.34 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 366,708,326.56 | 299,264,115.13 |
| 351 | Түүхий эд материал | 116,488,912.30 | 120,513,695.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 104,982,546.30 | 115,545,425.80 |
| 35130 | Эм боох материал | 11,506,366.00 | 4,968,270.00 |
| 354 | Хангамжийн материал | 190,481,668.26 | 124,616,425.33 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 19,039,520.00 | 7,213,882.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,574,605.33 | 1,955,120.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,835,570.00 | 1,255,270.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 38,278,802.43 | 4,575,410.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,319,850.00 | 4,472,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,208,822.00 | 408,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 101,224,498.50 | 104,735,442.83 |
| 35600 | Мал амьтад | 59,737,746.00 | 54,133,994.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,585,763,121.97 | 6,088,135,128.95 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,585,763,121.97 | 6,088,135,128.95 |
| 392 | Биет хөрөнгө | 5,338,902,721.97 | 5,840,754,728.95 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,898,093,029.00 | 4,901,141,779.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -169,069,468.98 | -323,544,723.06 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 647,177,511.90 | 1,057,469,190.36 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -401,684,177.03 | -484,198,372.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 564,860,674.61 | 923,904,551.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -379,315,388.33 | -428,030,242.95 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 167,628,134.80 | 171,103,360.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -65,819,895.32 | -56,606,286.45 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 42,788,342.78 | 42,788,342.78 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 69,371,845.75 | 74,513,045.74 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -35,127,887.21 | -37,785,916.46 |
| 393 | Биет бус хөрөнгө | 246,860,400.00 | 247,380,400.00 |
| 39301 | Програм хангамж | 520,000.00 | 520,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -520,000.00 | |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 246,860,400.00 | 246,860,400.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,988,575,678.05 | 6,443,562,422.60 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,988,575,678.05 | 6,443,562,422.60 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,988,575,678.05 | 6,443,562,422.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,059,879,285.91 | 1,059,879,285.91 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,059,879,285.91 | 1,059,879,285.91 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 4,505,894,837.80 | 4,962,220,332.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,505,894,837.80 | 4,507,233,588.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 454,986,744.55 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 422,801,554.34 | 421,462,804.01 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,988,575,678.05 | 6,443,562,422.60 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 7,883,551,938.00 | 5,940,410,916.45 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,143,329,589.00 | 976,450,086.45 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,143,329,589.00 | 976,450,086.45 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,143,329,589.00 | 976,450,086.45 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 124,608,095.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,143,329,589.00 | 851,841,991.45 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,740,222,349.00 | 4,963,960,830.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,507,208,200.00 | 4,666,826,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,507,208,200.00 | 4,666,826,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 233,014,149.00 | 297,134,030.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 59,100,000.00 | 171,616,150.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 430,000.00 | 94,152,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 173,484,149.00 | 31,365,880.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,099,429,258.02 | 5,481,940,618.64 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,099,429,258.02 | 5,481,940,618.64 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,776,007,803.01 | 4,757,462,302.28 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,883,247,572.86 | 3,657,344,578.69 |
| 210101 | Үндсэн цалин | 1,715,723,969.92 | 1,461,986,523.96 |
| 210102 | Нэмэгдэл | 1,167,523,602.94 | 758,021,372.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 52,353,851.03 |
| 210104 | Урамшуулал | | 97,191,609.07 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 1,287,791,222.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 69,074,659.69 | 97,200,850.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,804,026.37 | 24,017,721.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 63,270,633.32 | 73,183,129.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 141,683,593.94 | 141,294,755.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,856,188.52 | 21,590,475.26 |
| 210302 | Түлш, халаалт | 114,524,925.42 | 114,204,280.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,302,480.00 | 5,500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 163,962,943.04 | 353,568,304.43 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,173,620.00 | 36,770,511.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 111,583,244.17 | 184,471,082.43 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,294,006.47 | 29,283,894.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, | 232,000.00 | 700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,888,430.00 | 58,536,661.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 20,791,642.40 | 43,806,156.00 |
| 2105 | Нормативт зардал | 37,331,128.00 | 94,872,373.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 506,500.00 | 10,738,096.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,824,628.00 | 84,134,277.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 129,019,210.00 | 15,237,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 129,019,210.00 | 15,237,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,272,000.00 | 41,072,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,272,000.00 | 41,072,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, | 68,357,026.00 | 30,757,568.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 59,733,928.00 | 26,348,025.78 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,010,878.00 | 1,298,243.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 216,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | 1,188,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,612,220.00 | 1,707,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 267,059,669.48 | 326,113,471.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,685,322.00 | 7,904,241.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,742,900.00 | 2,404,250.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 252,631,447.48 | 315,804,979.71 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 323,421,455.01 | 724,478,316.36 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 300,200,741.00 | 712,142,795.16 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,976,340.00 | 9,507,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 183,233,771.00 | 472,877,558.16 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 23,728,396.00 | 160,737,937.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 85,262,234.00 | 69,020,300.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 23,220,714.01 | 12,335,521.20 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,220,714.01 | 12,335,521.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 3,784,122,679.98 | 458,470,297.81 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 2,104,327.26 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 2,104,327.26 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 0.00 | -2,104,327.26 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 3,784,122,679.98 | 456,365,970.55 |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,740,222,349.00 | 5,135,700,674.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 0.00 | 171,739,844.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 0.00 | 171,739,844.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0.00 | 171,739,844.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 124,608,095.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 47,131,749.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,740,222,349.00 | 4,963,960,830.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,507,208,200.00 | 4,666,826,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,507,208,200.00 | 4,666,826,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 233,014,149.00 | 297,134,030.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,100,000.00 | 171,616,150.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 430,000.00 | 94,152,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 173,484,149.00 | 31,365,880.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,803,234,240.20 | 5,101,897,399.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,803,234,240.20 | 5,101,897,399.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,479,528,217.19 | 4,370,207,941.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,896,666,317.78 | 3,684,312,217.69 |
| 210101 | Үндсэн цалин | 1,718,386,466.06 | 1,461,986,523.96 |
| 210102 | Нэмэгдэл | 1,040,538,186.34 | 784,989,011.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,158,413.00 | 52,353,851.03 |
| 210104 | Урамшуулал | 84,511,140.38 | 97,191,609.07 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,072,112.00 | 1,287,791,222.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 70,760,244.00 | 101,701,019.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,115,344.00 | 24,017,721.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 61,644,900.00 | 77,683,298.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 141,729,793.94 | 141,294,755.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,856,188.52 | 21,590,475.26 |
| 210302 | Түлш, халаалт | 114,571,125.42 | 114,204,280.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,302,480.00 | 5,500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 179,035,886.47 | 209,389,425.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,159,307.00 | 27,813,631.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 141,016,950.00 | 148,597,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,111,549.47 | 29,283,894.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, | 600,000.00 | 700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,148,080.00 | 2,994,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 38,082,739.00 | 76,001,055.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 778,500.00 | 2,200,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 35,804,239.00 | 72,301,055.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,252,480.00 | 69,069,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,814,000.00 | 3,207,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 44,438,480.00 | 65,862,050.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,272,000.00 | 46,295,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,272,000.00 | 46,295,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, | 77,650,376.00 | 35,507,568.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 60,856,898.00 | 29,778,025.78 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,010,878.00 | 1,298,243.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 4,000,000.00 | 216,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,612,220.00 | 2,508,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8,170,380.00 | 1,707,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,078,380.00 | 6,637,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,624,380.00 | 4,150,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,454,000.00 | 2,487,250.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 323,706,023.01 | 731,689,457.36 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 300,485,309.00 | 719,353,936.16 |
| 213204 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 10,865,900.00 | 9,507,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж | 183,223,771.00 | 473,328,199.16 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 23,728,396.00 | 160,737,937.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 82,667,242.00 | 75,780,800.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 23,220,714.01 | 12,335,521.20 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,220,714.01 | 12,335,521.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3) | -63,011,891.20 | 33,803,275.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 0.00 | 12,365,100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 12,365,100.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 12,365,100.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 12,365,100.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 0.00 | -12,365,100.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -63,011,891.20 | 21,438,175.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 21,877,796.00 | 32,568,777.18 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -41,134,095.20 | 54,006,952.18 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,059,879,285.91 | 422,801,554.34 | 4,505,894,837.80 | 5,988,575,678.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,059,879,285.91 | 422,801,554.34 | 4,505,894,837.80 | 5,988,575,678.05 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,059,879,285.91 | 422,801,554.34 | 4,505,894,837.80 | 5,988,575,678.05 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,059,879,285.91 | 422,801,554.34 | 4,505,894,837.80 | 5,988,575,678.05 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 1,338,750.33 | 1,338,750.33 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,059,879,285.91 | 422,801,554.34 | 4,507,233,588.13 | 5,989,914,428.38 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -1,338,750.33 | | -1,338,750.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 454,986,744.55 | 454,986,744.55 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,059,879,285.91 | 421,462,804.01 | 4,962,220,332.68 | 6,443,562,422.60 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,779,226,800. | 4,719,759,530. |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,779,226,800. | 4,719,759,530. |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,779,226,800. | 4,719,759,530. |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,587,760,100. | 3,560,556,094. |
| 210101 | Үндсэн цалин | 1,641,563,800. | 1,365,198,039. |
| 210102 | Нэмэгдэл | 1,278,503,500. | 758,021,372.03 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 50,080,000.00 | 52,353,851.03 |
| 210104 | Урамшуулал | 520,000,000.00 | 97,191,609.07 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 97,612,800.00 | 1,287,791,222. |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,683,300.00 | 73,183,129.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 77,683,300.00 | 73,183,129.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 141,294,800.00 | 141,294,755.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,590,500.00 | 21,590,475.26 |
| 210302 | Түлш, халаалт | 114,204,300.00 | 114,204,280.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 158,694,700.00 | 158,694,431.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,561,400.00 | 20,313,631.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 127,898,900.00 | 128,052,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,540,400.00 | 6,633,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,994,000.00 | 2,994,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 17,399,100.00 | 17,399,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,599,100.00 | 15,599,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 50,560,700.00 | 50,560,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,000,000.00 | 13,232,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 37,560,700.00 | 37,328,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 28,905,400.00 | 23,682,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 28,905,400.00 | 23,682,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 27,146,600.00 | 23,889,568.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,600,000.00 | 19,348,025.78 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,303,300.00 | 1,298,243.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 216,200.00 | 216,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,320,000.00 | 1,320,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,707,100.00 | 1,707,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 2,487,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 2,487,250.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 687,282,100.0 | 687,281,136.16 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 687,282,100.0 | 668,011,900.36 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,115,900.00 | 2,115,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 473,328,200.0 | 472,877,558.16 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 160,738,000.0 | 160,737,937.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 51,100,000.00 | 32,281,405.20 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,779,226,800. | 4,719,759,530. |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,666,826,800. | 4,595,301,435. |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,666,826,800. | 4,642,710,610.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 112,400,000.0 | 124,458,095.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 112,400,000.0 | 124,458,095.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 295,949,804.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 295,949,804.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 290,949,804.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.00 | 96,788,484.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 96,788,484.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.00 | 24,017,721.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 24,017,721.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.00 | 50,694,994.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 7,500,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 20,545,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 22,649,994.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 58,646,955.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 1,900,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 56,746,955.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0.00 | 30,873,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 2,340,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 28,533,650.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0.00 | 17,390,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 17,390,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.00 | 8,388,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 7,200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,188,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 4,150,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 4,150,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 5,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 5,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 5,000,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,449.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 15,449.0 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. *Авто машины засвар үйлчилгээнд ашигласан 14,000.0 мянган төгрөгийн сэлбэгийг зарлага болгохгүйгээр үлдэгдлээр илэрхийлж буруу тайлагнасныг анхан шатны баримтад үндэслэн зарлага болгон бараа материалын тайлангийн үлдэгдлийг үнэн зөвөөр илэрхийлүүлсэн.*
2. *Эм боох материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 1,449.0 мянган төгрөгийн угаалгын машин бүртгэснийг машин тоног төхөөрөмж дансанд шилжүүлэн бүртгүүлж, залруулсан*

Аудитаар нийт 8,756.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 8,756.7 мянган төгрөгийн хөрөнгийн данс бүртгэл, үйл ажиллагааны орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 6,465.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1**. Авлагын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт: Эзэн холбогдогч нь тодорхойгүй 3,535.4 мянган төгрөгийн авлагыг он дамжуулан бүртгэсэн нь авлагын хяналт, бүртгэлийн тогтолцооны тодорхой бус байдлыг илтгэж байна. Үүний улмаас санхүүгийн тайлангийн бодит байдал алдагдаж, авлагын төлбөрийн менежмент, хяналт дутагдаж, зөрчил үүсэх эрсдэл нэмэгдсэн.*

*Өгсөн зөвлөмж*: Байгууллагын авлагын дансанд он дамжин бүртгэгдсэн авлагын учир шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоож, барагдуулах ажлыг зохион байгуулах;

**2. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт: Эрх бүхий албан тушаалтнаас байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн газрыг данс бүртгэлд тусгаагүй нь эдийн засгийн хувьд үнэ цэнтэй нөөцийн бүртгэл алдагдсан, санхүүгийн тайланд бодит байдал хийгээд хууль тогтоомжийн дагуу шаардлагатай бүртгэл оруулаагүй гэсэн асуудал үүсгэж байна.*

*Өгсөн зөвлөмж*: Тухайн шатны Засаг даргын шийдвэрээр цагдаагийн газарт эзэмшүүлсэн газрыг e-gazar.gov.mn цахим системтэй тулган, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх*;*

**3. Орлогын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт: НХЗЭ зардлаас хоолны зардалд 1,140.0 мянган төгрөгийг зарцуулсан нь эдийн засгийн ангилалд тохирохгүй зарцуулалт байсан бөгөөд үүний улмаас*

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*төсвийн зарцуулалтын ангилалд зохих шаардлага хангахгүй тайлагнал үүссэн. Энэ нь төсвийн үр ашгийг үнэлэх, хяналтыг хангах боломжийг хязгаарлаж, санхүүгийн сахилга бат алдагдах эрсдэл үүсгэж байна.*

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авч бүлэг хооронд нь шилжүүлж захиран зарцуулах*;*

**4. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт*</u>*: Эрүүлжүүлэх болон баривчлах байрны төлбөр 1,790.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.*

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Эрүүлжүүлэх, баривчлах байрны төлбөрийг цаг тухай бүр нь авч төсвийн дансанд төвлөрүүлэх*;*

**5. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт*</u>*: Хичээл үйлдвэрлэлийн зардлаас албаны чиг үүрэгт хамааралгүй волейболын сургалтын төлбөрийг санхүүжүүлсэн нь төсвийн зарцуулалт, эдийн засгийн ангилалд тохирохгүй бөгөөд үүний улмаас төсвийн үр ашиг, хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсгэж байна*

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, төсвийн үр ашиг, хяналтын тогтолцоог сайжруулах*;*

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн | | Дүн |
| бараа материал дансанд ахөрөнгө бүртгэсэн | 1 | 1,449.00 | 1 | 1,449.00 | 1 | 1,449.00 | | | | |
| зарцуулсан материалыг үлдэгдлээр илэрхийлсэн | 1 | 14,000.00 | 1 | 14,000.00 | 1 | 14,000.00 | | | | |
| Дүн | 2 | 15,449.0 | 2 | 15,449.0 | 2 | 15,449.0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Авлага он дамжин бүртгэсэн | 1 | 3,535.4 | | | | | 1 | 3,535.4 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Газар дансанд бүртгээгүй | 1 | - | | | | | 1 | - | | |
| Төлбөр дутуу төвлөрүүлсэн | 1 | 1,790.0 | | | | | 1 | 1,790.0 | | |
| мөнгөн хөрөнгийг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй | 1 | 1,140.0 | | | | | 1 | 1,140.0 | | |
| Албан чиг үүрэгт хамааралгүй зардал гаргасан | 1 | 2,291.3 | | | | | 1 | 2,291.3 | | |
| Дүн | 5 | 8,756.7 | 0 | - | | | 5 | 8,756.7 | 0 | - |